

АКАДЕМИЧ ЧУЛУУНЫ ДАЛАЙН ЭРДМИЙН ӨВ ЕСӨН БОТЬ БҮТЭЭЛИЙН НЭЭЛТЭД ЗОРИУЛСАН ТАНИЛЦУУЛГА

Р.Төрдалай

*ШУА-ийн Олон улсын харилцааны хүрээлэнгийн
Эрдэмтэн нарийн бичгийн дарга, доктор (PhD)*

I. Чулууны Далай - “Монгол судлалын шилдэг өв”

Монгол Улсын Шинжлэх ухааны гавьяат зүтгэлтэн, Академич, Түүхийн шинжлэх ухааны доктор, профессор Чулууны Далайн мэндэлсний 90 жилийн ойн хүрээнд ШУА-ийн Олон улсын харилцааны хүрээлэнгийн Эрдмийн Зөвлөлийн шийдвэрээр академичийн эрдэм судлалын 9 ботийг Монгол судлалын Үндэсний зөвлөлийн дэмжлэгтэйгээр “Монгол судлалын шилдэг өв” цувралд анх удаа цогцоор нь эмхэтгэн нийтлүүлж, “Олон улс судлал-2020” эрдэм шинжилгээний хурлыг Ч.Далайн нэрэмжит болгон Хятад орон судлалын чиглэлээр дагнан зохион байгуулж байна.

Энэхүү эрдэм шинжилгээний хурлын үеэр академичийн эрдмийн бүтээлийн бүрэн эмхэтгэл 9 ботийн нээлтийг цаг үеийн нөхцөл байдалтай уялдуулан цахимаар зохион байгуулж, нээлтийн үг хэлж, арга хэмжээг нээж өгсөн ШУА-ийн Олон улсын харилцааны хүрээлэнгийн захирал, 9 боть бүтээлийн Ерөнхий редактор, доктор, дэд профессор Дашнямын Золбоод талархлаа илэрхийлж байна.

Академичийн ном бүтээлүүд сүүлийн 10 гаруй жил шинэчлэгдэн хэвлэгдээгүй тул өдгөө олдоц ховордож, хол, ойрын хүн сураглах нь багагүй болсон тул ШУА-ийн Олон улсын харилцааны хүрээлэнгийн эрдмийн хамт олноос ахмад үеийн нэрт эрдэмтдийн бүтээлийн цуврал гаргах, эрдэмтэн судлаачид болон өргөн олны хүртээл болгохыг зорин Хүрээлэнгийн захирлын тушаалаар холбогдох Редакцийн зөвлөл, Ажлын хэсэг байгуулагдсан билээ.

Монголын түүхийн бараг бүхий л үеийг хамарсан өргөн цар хүрээтэй сэдвээр судалгаа хийн Монгол Улсад дорно дахин судлал, тухайлан Зүүн хойд Ази судлалыг хөгжүүлэх, тодорхой чиглэл, үзэл баримтлалыг бий болгосон их эрдэмтний бүтээлийг эмхэтгэх нь нүсэр ажил болох нь дамжиггүй.

Академич нь Монголын түүхийн судалгааны хэд хэдэн чиглэлээр илүүтэй анхааран судалж, өөрийн үзэл номлол, байр суурийг дэвшүүлэн гаргаж, Хамаг Монгол, Их Монгол, Монголын Эзэнт гүрэн, Чингис хааны төрийн бодлого,

үйлс замналын тухай, Монголын угсаатан үүсэж бүрэлдсэн түүх ба төрт ёсны уламжлал, шашин, соёл, Монгол, Төв Азийн соёл иргэншил, үндэсний сэргэн мандлын тухай, Монгол-Хятад, Монгол-Япон, Монгол-Солонгосын түүхэн харилцааг хамарсан өргөн хүрээтэй судалгаа хийсэн байна.

II. Есөн ботийн агуулга, ач холбогдлын тухайд

“Монгол судлалын шилдэг өв” цувралд багтаж буй академичийн 9 боть бүтээл нь судалгааны чиглэл, дэвшүүлсэн зорилтынхоо хүрээнд Монгол Улсад түүх, орон судлал, соёл, сэтгэлгээний нээлтүүд болохуйц анхдагч шан татсан бүтээлүүд байсныг тэмдэглэх нь зүйтэй байна. Өөрөөр хэлбэл, академичийн бүтээлүүд нь тухайн цаг үеийнхээ үзэл суртлын халхавчнаас даван гарч, үнэнийг эрэлхийлэх шинжлэх ухаанч хандлага, эх оронч үзэл шингэсэн байдгаараа хэлмэгдэл хавчлагын хүнд бэрхэд дайрагдаж байсан ч он цагийн уртад үнэн цэн нь алдрахгүй, олны анхаарал сонирхлоос ч ангижирсангүй билээ.

Энэхүү танилцуулгадаа, академичийн 9 боть бүтээл тус бүрийн шинжлэх ухааны ач холбогдлын талаар эрдэмтдийн өгсөн дүгнэлтийг товчхон авч үзье.

Есөн боть цувралын Тэргүүн болон Дэд ботид Хамаг Монгол Улс, Их Монгол Улс, Юань гүрэн (1260-1368 он)-ий үеийн Монголын түүх багтаж байгаа бөгөөд судалгааны эдгээр бүтээлийн агуулга, шинжлэх ухааны ач холбогдлын талаар уг ботийг эрхэлсэн доктор Цэгмэдийн Цэрэндорж өмнөх үгэндээ тодорхой дүгнэлт өгсөн байна.

Түүний дүгнэснээр “Хамаг Монгол улс” хэмээх бүтээл нь хэмжээгээр бага хэдий ч, тухайн үед харьцангуй бага судлагдаад байсан Монголын нэгдсэн төр улсын үндэс мөхлөг болсон Хамаг Монгол улсын түүхийг улируулан судалж, нэгдмэл үнэлэлт дүгнэлт, ойлголтыг судлаач, уншигчдад өгөх зорилготой байсан¹ бөгөөд зохиогчийн өөрийн нь онцлон тэмдэглэснээр “Ер нь Хамаг Монголын түүхийн зангилаа асуудлыг гүйцэд судалж гаргаж чадвал тэр үеийн Монголын нийгмийн байгуулал, нийт Монгол орны ерөнхий дүр төрхийг төсөөлөн гаргаж болно” хэмээн үзэж, эл үеийн түүхийг нэгтгэсэн бүтээл гаргах нь “Монголын түүхийн хамгийн чухал тэр үеийг цаашид гүйцэд судалж, бүрэн түүх гаргахын эхлэл төдий юм” хэмээн даруухнаар тэмдэглэсэн байдаг гээд ямартай ч тус бүтээл нь “Хамаг Монгол улс”-ын түүхээр “овоглосон” хамгийн анхны зохиол төдийгүй, энэ чиглэлээр судалгаа хийж ирсэн манай ахмад эрдэмтэд, гадаад, дотоодын бусад эрдэмтдийн судалгааг бүхэлд нь хамруулахыг оролдсоноороо ихээхэн ач холбогдолтой юм хэмээн уг бүтээлийг үнэлжээ.²

Чулууны Далай академич “Их Монгол Улс” бүтээлийнхээ гол онцлогийг “Их Монгол Улсын түүхийг дан ганц түүхийн сурвалжид түшиглэн бичиж өөрийн

1 Академич Чулууны Далай: *Бүтээлийн эмхэтгэл*, 9 боть бүтээл, I Боть, Эрхэлсэн доктор Ц.Цэрэндорж, БСШУСЯ-ны дэргэдэх Монгол судлалын үндэсний зөвлөлийн дэмжлэгтэйгээр ШУА-ийн Олон улсын харилцааны хүрээлэнгээс эрхлэн гаргав, Улаанбаатар, 2020.

2 Мөн тэнд

гэсэн ажиглалт хийх нь дутмаг, тал бүрээс нь монгол хүний нүдээр харж цэгнэн бодож, эргэцүүлэн сэтгэх явдал дутуу дулим хийгдэж ирсэн” тул “зохиолоо бичихдээ түүхийн сурвалжид эзэмдэгдэн хөтлөгдөх биш, тэдгээрийг олон талаас нь нарийвчлан судалж монгол хүний зан төрх, ёс заншил, ахуй үйлтэй нягт холбон үзэж тайлбарлах”-ыг оролдсон агаад тус судалгаа нь өмнөх үеийн эрдэмтдийн судалгааны “үргэлжлэл бөгөөд нэмэлт болно” хэмээн тодорхойлсон байна.¹

Харин “Монголын түүх (1260-1368 он)” бүтээлийн тухайд Монголын түүхийг боловсруулан судлах явдал эрдэм шинжилгээний төдийгүй, бас улс төрийн чухал ач холбогдолтой гэж академич үзэж байсан талаар доктор Ц.Цэрэндорж дурдаад² “Монгол, Хятадын харилцаанд гарсан түүхийн энэ ээдрээтэй үеийг өөрийн эрхгүй хутган дүгнэх, өөрсдийнхөөрөө зүтгэн бичих, их гүрний үзэлд тохируулахыг оролдох явдал гаднын түүхчдийн дотор оршсоор байна” хэмээн зарим түүх гуйвуулах явдлыг илчлэн бичсэн байдаг тул зохиогч бүтээлээ “Юан гүрэн” гэх мэтээр нэрлэлгүй, “Монголын түүх” хэмээсэн нь ч иймэрхүү улс төрийн учир шалтгаантай болов уу гэсэн судалааны таамаглалаа дэвшүүлсэн байна.³

Тус цувралын Гуравдугаар ботид багтаж буй “Юань гүрний үеийн Монгол”, “Монголия в XIII-XIV веках” бүтээлүүд бол академичийн Монголын эзэнт гүрний түүхийн сэдвээр туурвисан бүтээлийн ноён оргил, олон арван жилийн нөр их судалгааны нь үр дүн юм. Өгүүлэн буй үеийн Монголын түүхийг Монгол Улсад тусгайлан судалсан анхны түүхч бол Ч.Далай бөгөөд эл үеийн түүхийн хожим гарсан бүтээлүүд чухамхүү түүний бүтээл дээр суурилсан хэмээн үзэхэд буруудахгүй билээ.



1 Мөн тэнд

2 Мөн тэнд

3 Академич Чулууны Далай: *Бүтээлийн эмхэтгэл*, 9 боть бүтээл, I Боть, Эрхэлсэн доктор Ц.Цэрэндорж, БСШУСЯ-ны дэргэдэх Монгол судлалын үндэсний зөвлөлийн дэмжлэгтэйгээр ШУА-ийн Олон улсын харилцааны хүрээлэнгээс эрхлэн гаргав, Улаанбаатар, 2020.

Энэ тухай профессор С.Цолмон бичихдээ, энэ бүтээл нь ЗХУ-ын ШУА-ийн Дорно дахин судлалын хүрээлэнд их эрдэмтний түүхийн ухааны дэд эрдэмтний зэрэг хамгаалсан бүтээл, мөн Монголын түүх судлалд хятад болон бусад хэлний сурвалжийг илүү өргөн хүрээтэй ашигласан анхны бүтээлүүдийн нэг байсан учир уншигч олноо толилуулах нь эрдэм шинжилгээний болоод танин мэдэхүйн чухал ач холбогдолтой хэмээн санана. Бидний хэвлүүлж буй энэхүү бүтээл нь тухайн үед Монголын түүхийн хамгийн бага судлагдсан Юань гүрний үеийн уугуул Монгол орон, монголчуудын түүх бөгөөд үзэл суртлын хэлмэгдэлд өртөж шатаагдаж байсан нь олон түмний түүхээ мэдэх хүсэлд саад тотгор болж олж унших боломжийг хязгаарласан хэрэг болсон билээ”¹ гэж үзсэн байдаг.

Харин дөрөвдүгээр ботийн тухайд, профессор На.Сүхбаатар “Ойрад Монголын түүх” бүтээл бол Монгол Улсад Ойрадын түүхийг анх удаа нэгтгэн бичсэн судалгааны ажил болно. Нийт 10 бүлэг, 30 зүйл, дэлгэрэнгүй удиртгал, төгсгөлөөс бүрдсэн, 1750-иад оны төгсгөл буюу Зүүнгар улс мөхөх хүртэлх үеийг хамарсан нэгэн сэдэвт бүтээл юм. Ойрад судлалын хүрээний сурвалж бичгүүд, олон улсын хэмжээнд гарсан судалгааны бүтээлүүдийг хамарсан ХХ зууны төгсгөл үеийн түүх судлалын түвшинг илтгэх бүтээл болно. Тус бүтээл өнөө үед ойрад судлалын чиглэлийн гол суурь бүтээл хэвээр байж, харин дэвшүүлсэн санал дүгнэлтүүд улам нарийсан хөгжсөөр байна гэжээ.²

Их эрдэмтний бүтээлийн эмхэтгэлийн Тавдугаар боть нь “Монголын бөө мөргөл” ном бөгөөд доктор Д.Золбоо энэхүү бүтээлийн ач холбогдол, онцлогийг дараах байдлаар өгүүлсэн байна. Түүний бичсэнээр уг бүтээл нь Ч.Далайн БНХАУ-ын Бээжингийн Их сургуулийг түүхч мэргэжлээр төгсөхдөө хамгаалсан дипломын ажил болохын хувьд эрдэм судлалын анхны бүтээл нь хэмээн үзсэн байна. Уг судалгааг Бээжингийн их сургуулийн багш профессор Шао Шэньжэн удирдсан бөгөөд 1959 онд Улаанбаатар хотод зохион байгуулагдсан Олон улсын монголч эрдэмтдийн анхдугаар их хуралд зориулан “Монголын бөөгийн мөргөлийн товч түүх” нэртэйгээр Ш.Нацагдорж гуай редакторлан анх хэвлүүлжээ. Түүнээс хойш 1978 онд Бээжинд хятадаар, 1990 онд Хөх хотод монголоор хэвлэгдсэн ажээ. Бүтээлийн эрдэм шинжилгээний үнэ цэнийг доктор Л.Түдэвийн “Эрдмийн Далай” өгүүлэл болон 2000 онд Ч.Далайн 70 насны ойд зориулан Улаанбаатар хотын Нийтийн номын санд зохион байгуулсан Эрдэм шинжилгээний хуралд доктор О.Пүрэвийн “Монголын бөө мөргөлийн судлал ба академич Ч.Далай” илтгэл зэрэг олон бүтээлд товч, тодорхой үнэлсэн байдаг.³

1 Академич Чулууны Далай: *Бүтээлийн эмхэтгэл*, 9 боть бүтээл, III Боть, Эрхэлсэн доктор С.Цолмон, БСШУСЯ-ны дэргэдэх Монгол судлалын үндэсний зөвлөлийн дэмжлэгтэйгээр ШУА-ийн Олон улсын харилцааны хүрээлэнгээс эрхлэн гаргав, Улаанбаатар, 2020.

2 Академич Чулууны Далай: *Бүтээлийн эмхэтгэл*, 9 боть бүтээл, IV Боть, Эрхэлсэн доктор На.Сүхбаатар, БСШУСЯ-ны дэргэдэх Монгол судлалын үндэсний зөвлөлийн дэмжлэгтэйгээр ШУА-ийн Олон улсын харилцааны хүрээлэнгээс эрхлэн гаргав, Улаанбаатар, 2020.

3 Академич Чулууны Далай: *Бүтээлийн эмхэтгэл*, 9 боть бүтээл, V Боть, Эрхэлсэн доктор Д.Золбоо, БСШУСЯ-ны дэргэдэх Монгол судлалын үндэсний зөвлөлийн дэмжлэгтэйгээр ШУА-ийн Олон улсын харилцааны хүрээлэнгээс эрхлэн гаргав, Улаанбаатар, 2020.

Уг бүтээлийн 2009 онд гарсан хоёр дахь хэвлэл академичийн амьд ахуйдаа гаргасан хамгийн сүүлийн бүтээл гэж болохоос гадна анхдугаар их хуралд нь зориулж байсан Олон улсын Монгол судлалын холбооныхоо 50 жилийн ойд зориулан гаргаснаараа ихээхэн онцлогтой юм. Хоёр дахь хэвлэлийн өмнөхөөсөө ялгарах онцлогийн талаар академичийн мэндэлсний 80 жилийн ойд зориулан 2010 онд Монгол Улсын Их Сургуульд зохион байгуулсан эрдэм шинжилгээний хуралд доктор С.Өлзийбаяр, доктор Ю.Болдбаатар нарын тавьсан илтгэлд тодорхой дурдсан ажээ. Ингэснээр уг цувралын Тавдугаар боть нь их эрдэмтний анхны болон сүүлийн бүтээлийг багтаасан боть болсон бөгөөд энэ нь Монголын бөө мөргөлийн судалгаа байсан нь сонирхол татаж байна.

Академич Ч.Далайн эрдмийн бүтээлийн эмхэтгэлийн 6 дугаар ботид гол төлөв XIII, XIV зууны Монголын түүх, Ойрад судлалд холбогдох нийтдээ 29 эрдэм шинжилгээний өгүүлэл, шүүмж, 1 номыг оруулж, зарим түүхэн хүн, газар усны нэрийг дуудлагаар, эсвэл хэллэг өөрөөр бичсэнийг уг эхэд байгаагаар үлдээсэн бол¹ 7 дугаар боть нь их эрдэмтний өргөн хүрээг хамарсан судалгаа, эрдэм шинжилгээний ажлын нэгэн гол чиглэл болох Хятад судлал, Монгол-Хятадын харилцааны асуудлыг хөндсөн бүтээлүүдээс бүрджээ. Уг ботид Хятад судлалын чиглэлээр дангаар болон гадаад дотоодын эрдэмтэдтэй хамтран холбогдох сэдвийн дагуу бичсэн нэгэн сэдэвт зохиол, эрдэм шинжилгээний өгүүлүүдээс гадна олон улсын эрдэм шинжилгээний хуралд тавьсан илтгэлүүд, дурсамж яриа, хэвлэлд өгсөн ярилцлагуудыг багтсан байна.

Доктор Д.Шүрхүү, Д.Базардорж нар 7 дугаар ботид багтсан эрдэм шинжилгээний бүтээлүүдэд дараах онцлог буйг ажиглан тэмдэглэсэн бичихдээ:

Нэг. Ботид орсон эрдэм шинжилгээний бүтээлүүдийн агуулга нь цаг хугацааны хувьд XIII зуунаас социалист систем задран унахын өмнөх үеийг хамарсан ба монгол, орос хэлээр бичигджээ. Зарим өгүүлэл, илтгэл монгол, орос хоёр хэлээр хоёр газарт хэвлэгдэн, хоёр газарт хэлцэгдсэнийг уншигчдад хэлний сонголттойгоор үзэх боломжийг олгох зорилгоор нэг дор зэрэгцүүлж байрлуулав. Харин дурсамж, ярилцлага нь шинэ зуун гарсны дараа бичигдэж нийтлэгдсэн байна.

Хоёр. “Хүйтэн дайн”-ы жилүүдэд социалист систем ч дотроо хагарч ЗХУ, БНХАУ хэмээх хоёр их гүрэн үзэл суртлаар зөрөлдөн, тэр ч бүү хэл зэвсэгт мөргөлдөөнд ч хүрч, харилцан биесээ буруушаан сурталдаж байсан үед манай улс олон талын шалтгаанаар Зөвлөлтийн байр суурийг тууштай баримталж, үзэл суртлын хүрээнд Хятадтай харилцан шүүмжлэлцэж байсан юм. Тийм эгзэгтэй түүхэн орчинд эдгээр бүтээлүүд бичигдсэн байна.

Гурав. Цаг үеийн онцлогоос шалтгаалан төр засгаас баримталж байсан бодлого, үзэл санааны хүрээнд нэлээд өгүүлэл нь гадаад, дотоодод улс орныхоо нэр хүндийг бататган хамгаалах, нийгэм олон нийтийг ухуулан сурталчлах,

¹ Академич Чулууны Далай: *Бүтээлийн эмхэтгэл*, 9 боть бүтээл, VI Боть, Эрхэлсэн доктор О.Батсайхан, БСШУСЯ-ны дэргэдэх Монгол судлалын үндэсний зөвлөлийн дэмжлэгтэйгээр ШУА-ийн Олон улсын харилцааны хүрээлэнгээс эрхлэн гаргав, Улаанбаатар, 2020.

Хятадын суртал ухуулгыг няцаан дарах, Хятад дахь үйл явдлуудыг шүүмжлэн буруушаахад чиглэгдсэн ба улс төрийн өнгө аясыг гүн шингээж бичигджээ.

Дөрөв. Улс төрийн өнгө аяс давамгайлсан өгүүллүүдээ зарим үед “Ч.Чавх”, “О.Чулуун” гэх халхавч нэрээр хэвлүүлж байсны шалтгаан учрыг тайлбарлах явдалгүй болов уу. Халхавч нэрээр өгүүлэл бүтээлээ хэвлүүлэх явдал тухайн үед тус хүрээлэнгийн эрдмийн хамт олны дунд түгээмэл байсныг дурдаад дээрх мэтээр цаг үеийн онцлогуудыг шингээсэн агуулга энэхүү боть дахь эрдэм судалгааны ажилд нэлээд түгээмэл буй ч тэдгээр нь манай улсын хятад судлалын хөгжлийн нэгэн үеийн өнгө төрхийн илэрхийлэл болон үлдэж байна гэсэн голч дүгнэлт хийжээ.¹

Академич Далай багшийн асар өргөн цар хүрээтэй судалгааны нэгээхэн хэсэг нь бүс нутаг судлалын чиглэл болно. Тэрбээр бүс нутгийн олон улсын харилцааны өрнөл хөгжил, Орос, Хятад, Япон, Өмнөд Солонгос орнуудын хөгжлийн шинж, онцлог, туршлага сургамжийг Монгол Улсын хөгжлийн чиг хандлагатай нягт уялдуулан судалж, үнэлэлт дүгнэлт өгсөн нь өнөөдөр ч ач холбогдолтой хэвээр байна.

Тэрбээр энэ тухайд нэгэнтээ “Монгол Улс маань өөрийн оршин буй энэхүү бүс нутгийн улс орнуудтай өргөн харилцаа, хамтын ажиллагаатай, бүс нутгийн эдийн засгийн интеграцид харилцан хамааралтай болж, бүс нутгийн түүхий эдийн хавсарга төдий байх бус зах зээлийн харилцаанд зохицсон эдийн засгийн үр ашигтай загвар бүхий нүүдэл суурин иргэншлийг хосолсон, экологи-эдийн засгийн цэвэр орчноо хадгалсан, өрнө дорныг холбосон өндөр хөгжилтэй, ард түмэн нь аз жаргалтай улс орон...” байх болно² хэмээн бүтээл туурвилдаа онцлон тэмдэглэсэн байдаг. Түүний эл үзэл санаа 8 дугаар ботид багтсан бүтээлүүдэд нь бодитоор тусгалаа олж, доктор Ц.Баатар, Б.Сэржав нар тус ботийн өмнөх үгийг бичжээ.

9 дүгээр ботийн тухайд доктор Г.Дашням, Ш.Догмийчойдон нараас эрхлэн эрдэмтний намтар, эрдэм судлалын үйл ажиллагаанд холбогдох архивын баримт материалыг эмхэтгэн гаргалаа. Уг ботид “Далай судлал”-д холбогдох олон сонирхолтой шинэ баримт багтаж, судалгааны эргэлтэд орсон юм.

Ийнхүү Монгол Улсын Шинжлэх ухааны гавьяат зүтгэлтэн, академич Чулууны Далайн мэндэлсний 90 жилийн ойд зориулан түүний эрдэм судлалын 9 боть цогц бүтээлийг анх удаа эмхэтгэн гаргах энэхүү ажил ШУА-ийн Олон улсын харилцааны хүрээлэнгийн эрдмийн хамт олон, тус ботийг эмхэтгэн гаргахад оролцсон олон байгууллагын эрдэмтдийн хамтын хүчин чармайлтаар амжилттай хэрэгжлээ.

1 Академич Чулууны Далай: *Бүтээлийн эмхэтгэл*, 9 боть бүтээл, VII Боть, Эрхэлсэн доктор Д.Шүрхүү, Д.Базардорж, БСШУСЯ-ны дэргэдэх Монгол судлалын үндэсний зөвлөлийн дэмжлэгтэйгээр ШУА-ийн Олон улсын харилцааны хүрээлэнгээс эрхлэн гаргав, Улаанбаатар, 2020.

2 Академич Чулууны Далай: *Бүтээлийн эмхэтгэл*, 9 боть бүтээл, VIII Боть, Эрхэлсэн доктор И.Энхболд, Б.Цэнгэлхам, БСШУСЯ-ны дэргэдэх Монгол судлалын үндэсний зөвлөлийн дэмжлэгтэйгээр ШУА-ийн Олон улсын харилцааны хүрээлэнгээс эрхлэн гаргав, Улаанбаатар, 2020.

Академичийн бичгийн өв сан нь Монгол Улсын Үндэсний Төв Архив, Гадаад харилцааны яамны Гадаад харилцааны Төв архив, Үндэсний номын сан, ШУА-ийн Олон улсын харилцааны хүрээлэнгийн архив, ШУА-ийн Түүх, угсаатны хүрээлэнгийн Сурвалж судлал, баримт мэдээллийн төвд голлон хадгалагдаж байгаа бөгөөд нэлээд гар бичмэл, баримт, эх хэрэглэгдэхүүн нь түүний шавь нар, үр хүүхдүүд, “Алтайн Далай сан” ТББ-д байна. Эдгээр төрийн болон хувийн архив сан хөмрөгт тулгуурлан бид энэхүү 9 боть бүтээлээ эмхэтгэн гаргаж байна.

Эрдэм судлалын энэхүү 9 боть бүтээлийг эмхэтгэхдээ академичийн хэвлүүлсэн анхны эхэд тулгуурлах зарчмыг барьж ажилласан бөгөөд зөв бичих дүрэм, хэл найруулгын тухайд зохиогчийн бичлэгийн онцлог, арга барилыг хөндөхгүй байхыг чухалчилж, илэрхий хэвлэлийн алдаа мадагтай зарим зүйлсийг залруулан зассан болно.

“Эрдмийн бүтээлийн эмхэтгэл” 9 ботийн ажлыг гүйцэтгэх явцад техникийн шинжтэй зарим засвар хийх шаардлага үүсэж байсныг тэмдэглэх нь зүйтэй бөгөөд үүнийг дараах аргачлалаар шийдвэрлэсэн болно. Үүнд:

1. Академичийн хэвлүүлсэн анхны эхэд тулгуурлах зарчмыг барьж ажилласан;
2. Зөв бичих дүрэм, хэл найруулгын тухайд эрдэмтний бичлэгийн онцлог, арга барил, тухайн үеийн зөв бичгийн дүрэм, найруулга зэргийг аль болох хөндөхгүй байхыг чухалчилсан;
3. Тухайн үеийн хэвлэлийн технологийн чадамжаас шалтгаалсан илэрхий алдаа мадагтай зарим зүйлсийг залруулсан;
4. Есөн ботид багтсан бүтээлүүдийн эшлэл, зүүлтийг нэгдсэн стандарттай болгосон;
5. Оноосон нэр /газар орон, гадаад хүний нэр, / гадаад ном бүтээлийн нэрийг тулган шинэчилж зассан;
6. Техник ажиллагаанаас үүдэлтэй ганц нэг тохиох утгын зарим жижиг алдаанд засвар тайлбар хийв. Чингэхдээ уг алдаатай эхийг хэвээр нь байлгаж хойно талд нь (...ред) тэмдэгтийг ашиглав.

III. Дүгнэн өгүүлэх нь:

Монгол Улсад орон судлал, гадаад бодлого, олон улсын харилцааны суурь судалгааг дагнан хэрэгжүүлэгч байгууллага болох ШУА-ийн Олон улс судлалын хүрээлэнгийн туулсан хагас зуун илүү жилийн эрдэм судлалын үйлс, бүтээсэн өвийг өнөөдөр эргэн харахад Монгол Улсын хөгжлийн суурь асуудал, оршин тогтнохуйн бодит баталгаа болсон гадаад орчин, түүний хувьсал өөрчлөлт, нөлөөлөл, үр дүн, түүх, үр дагаварыг шинжлэх ухаанч байдлаар нэгтгэн дүгнэх, төр засгийн байгууллагуудыг зөвлөмж, судалгаа, мэдээллээр хангах үүргээ биелүүлсээр иржээ. Хүрээлэнгийн энэхүү туулсан 50 гаруй жилийн түүхэн хугацааны дийлэнх хэсэг нь академич Чулууны Далай агсны эрдэм судлалын ажил үйлстэй нягт холбогдож байна.

Иймд, академич Чулууны Далайн эрдэм судлалын бүтээлийг судлах, сурталчлах, тухайлсан бүтээлийг хэвлүүлэн олон нийтэд хүргэх нь Монгол Улсын орон судлал, түүх, гадаад бодлогын суурь судалгааны хөгжилд чухал хувь нэмэр оруулна гэж үзэж байна.

Ч.Далай академичийн Монголын түүх, орон судлал, гадаад харилцааны талаар дэвшүүлсэн санал, зөвлөмж, эрдэм шинжилгээний үнэлэлт дүгнэлт нь өнөө хэр ач холбогдлоо алдаагүй бөгөөд дотоод, гадаадын эрдэмтэн судлаачдаас өндөр үнэлгээ авч, Монгол Улсын түүх, нийгмийн шинжлэх ухаанд бодитой хувь нэмрээ оруулсаар байгаа билээ.

Бидний хэрэгжүүлсэн энэхүү төсөл нь академич Чулууны Далайн амьдрал үйлс, эрдэм судлалын өв, Монгол Улсын шинжлэх ухаанд оруулсан бодит хувь нэмрийг цогц байдлаар гарган сурталчлах өргөн боломжийг нээх, хүрээлэнгээс төрөн гарсан ахмад үеийн эрдэмтдийнхээ үйл бүтээлийг сурталчлан алдаршуулах зорилгод чиглэгдсэн болно. “Эрдмийн бүтээлийн эмхэтгэл”-ийг цувралаар хэвлүүлэх ажил цаашид үргэлжлэх бөгөөд хүрээлэнгээс төрөн гарсан олон эрдэмтний шилдэг бүтээлүүд ботилон хэвлэгдэж олон түмэнд хүрэх болно.

“Олон улс судлал-2020” хэмээх энэхүү эрдэм шинжилгээний хурал нь академич Ч.Далайн олон жилийн судалгаа бүтээлээ зориулсан Хятад судлалын чиглэлээр зохион байгуулагдаж, Монголын Хятад орон судлалын хөгжлийн түүх, хүрсэн түвшин, орчин үе, хэтийн төлөвтэй холбогдох олон сонирхол татам асуудлыг хөндсөн илтгэлийг эрдэмтэн мэргэд хэлэлцүүлж байгаад баяртай байгаагаа илэрхийлж хурлын үйл ажиллагаанд амжилт хүсье.